

СОНИНЫ НИЙТЛЭЛИЙН ХЭЛ, НАЙРУУЛГА

Н.Мөнхзориг*

* "Идэр" дээд сургуулийн багш, магистр, докторант

Түлхүүр үг: сонины хэл, найруулга, нийтлэл, хянан тохиолдуулах арга, найруулгын алдаа.

Сонины хэл найруулга бол хэл шинжлэлийн таван салбар ухааны нэг найруулга зүйн үндсэн таван төрлийн нэг юм.

Нийтлэлийн хэл, найруулгад сонин, нийгэм улс төрийн сэтгүүл, суртал нэвтрүүлэг баримтат киноны тайлбар, хурал цуглаан, баяр ёслолын арга хэмжээнд хэлэх үгийн хэл, найруулга зэрэг хамаарна.

Сонин хэвлэл нь зөвхөн мэдээлэх, дамжуулах, учир зүйн тайлбар нотолгоо хийх төдийгүй сэтгэл зүйн хувьд нөлөөлөх үүрэгтэй. Мэдээлэх, нөлөөлөх хоёр үүрэг нь нэгдэж ирдэг. Ер нь нийт ОНМХ уншигч, сонсогч, үзэгчийн сэтгэлгээ, сэтгэл зүйд маш хүчтэй нөлөө үзүүлж чаддаг. Сонин нь олон түмний бүх давхаргад хүрч чаддаг, ихээхэн шуурхай, тогтмол гардаг, тухайн цаг

үеийн шинж төрхийг үзүүлж, тэр үеийнхээ түүхийг өгүүлж байдаг зэрэг онцлогтой. Бичлэгийн бусад төрөлтэй харьцуулахад сонины хэл найруулга хамгийн энгийн, ойлгоход хялбар, цөөн үгээр өргөн утга илэрхийлж байдгаараа ялгардаг. Сонины мэдээлэх үүрэг нь баримт хэрэглэгдэхүүн үнэн зөв байх, сэтгэхүйн хийсвэрлэлд тулгуурласан байх зэргээр илэрнэ.

Сонины хэл, найруулгын нөлөөлөх үүрэг нь уриалан дуудах, яруу сайхны таашаалд нийцэх, шинэ шинэ үг хэллэгээр илэрхийлэхийг эрмэлзэх, суртачлан зарлаж таниулах, шинэ шинэлэг аястай байх зэргээр илэрдэг. Сэтгэл хөдөлгөх уран үг, өвөрмөц хэллэг, хэлний яруу хэрэглүүрийг зохистой ашиглавал, уншигчдад нөлөөлөх үр өгөөж нь төдий чинээ их болно.

Сонины бичлэгийн төрөл зүйл бүр хэл найруулгын өвөрмөц онцлогийг шаарддаг. Тухайлбал: Мэдээ бичихэд үгийн шууд, бодит утгыг хэрэглэнэ.

Сонины хэл, найруулгын бүтцийн үндсэн зорилгыг зөв тогтооход, Оросын хэл шинжлэлчид ихээхэн хувь нэмэр оруулсан байна. Оросын судлаачид сонины хэл найруулгыг хамгийн өргөн хүрээтэй судалж, онол-практикийн асар их туршлага хуримтлуулсан юм. Хэдийгээр хэл тус бүр өөр өөрийн зүй тогтол, өвөрмөц онцлогтой байдаг боловч харилцан тусгаж авахаар онолын үндэслэл, судадагдгааны арга их байдаг. Оросын судлаачдаас анхлан профессор Г.О. Винокур 1920-оод оны үеэс сонинг хэл шинжлэлийн найруулга зүйн үүднээс тодорхойлохыг хичээж, энэ асууд-

лыг үндэслэсэн байна. Ингэхдээ хэлц болон тогтвортой холбоо үг (Орчин цагийн монгол хэлний чөлөөт бус холбоо үг)-ийн гүйцэтгэх үүргийг онцлон анхаарчээ. Түүний онолын гол үндэслэл бол сонины хэлний үндсэн шинж *хэвшмэлжин тогтсон байдаг* гэж үзсэн явдал юм. Харин уран яруу буюу хэвшмэлжин тогтсон байдлын эсрэг онцлогийг дурьдалгүй өнгөрчээ. Гэвч сонины хэлний бүрдлийн нэг онцлогийг тогтоосон нь ихээхэн ач холбогдолтой зүйл болжээ. Профессор Г.О. Винокур "Сонин бол найруулга дундын үгээр

голчлон бүтдэг бөгөөд үг ярианы бэлэн тогтсон хэв загварыг хэрэглэдэг нь сонины хэлний зайлшгүй шинж мөн" гэж онолын үндэслэлээ талбарласан байдаг. Үүнийг сонины хэлний үндсэн шинжийн нэг мөн гэж хэлшинжлэлчид санал нэгтэй хүлээн зөвшөөрдөг. Профессор В.Г.Костомаров онолын энэ үндэслэлийг хөгжүүлэн баяжуулж "Сонины хэлний

үндсэн зарчим нь бэлэн тогтсон үг хэллэг, уран яруу дүрслэл хоёрын диалектик нэгдэл мөн" гэж баталжээ.

Сонины хэлний онолын энэ үндэслэлийг оросын хэвлэл удирдлага болгон бүтээлчээр хэрэгжүүлж ирсэн байна. Профес-

сор В.Г.Костомаров бол сонины хэлийг онол-практикийн талаас нь хамгийн дорвитой судалсан эрдэмтдийн нэг юм. сонины хэлний өвөрмөц онцлогийн талаар хэдэн арван сонирхолтой өгүүлэл бичсэн төдийгүй 1971 онд "Сонины Орос хэл" гэсэн томоохон бүтээл хэвлүүлж, түүндээ онолын гол үндэслэлээ гаргажээ. Сонины хэл бол хэвшмэлжсэн хэллэгээр бүтдэг төдийгүй, бас уран яруу хэллэг, өвөрмөц дүрслэлээр бүрддэг бөгөөд "уран яруу болон хэвшмэлжсэн байдлын нэгдлийг эрхэмлэх нь сонины хэлний бүрлийн зарчим мөн" гэж

«

Бичлэгийн бусад төрөлтэй харьцуулахад сонины хэл найруулга хамгийн энгийн, ойлгоход хялбар, цөөн үгээр өргөн утга илэрхийлж байдгаараа ялгардаг. Сонины мэдээлэх үүрэг нь баримт хэрэглэгдэхүүн үнэн зөв байх, сэтгэхүйн хийсвэрлэлд тулгуурласан байх зэргээр илэрнэ.

»

онолын дүгнэлтээ хийсэн байна. Энэ дүгнэлтийг эрдэмтэн судлаачид зөв гэж үзээд, өвөрмөц онцлогийг нь улам баяжуулан хөгжүүлсээр иржээ.

Швейцарын хэлшинжлэлч Ш.Балли "Сонины хэл, найруулга тогтворжсон байдаг. Ингэхгүй бол яаж хурдан, зөв бичих вэ?" гэж сонины хэл хэвшмэлжин тогтох нь сэтгүүлчийн ажилд амар хялбар болох ач тустай гэсэн санаа гарган бичсэн байдаг. Энэ мэтчилэнгээр сонины хэлний ерөнхий зарчмыг дүгнэхийн зэрэгцээ тусгайлан нэг сонины онцлогийг гаргах, хэд хэдэн сонинг зэрэгцүүлэн судлах зэрэг ажил эрчимтэй хөгжиж ирсэн байна. сонины хэл, найруулгын онцлогийг зөв гаргах, бүтцийг үндэслэл сайтай тогтоох, оновчтой ангилах нь сонины хэл, найруулгыг баяжуулан сайжруулахад онол, арга зүйн чухал ач холбогдолтой юм.

Сонины хэлэнд ажиглалт хийхдээ: нэгдүгээрт: аль нэг сонины хэлний онцлогийг гаргах, хоёрдугаарт: тодорхой нэгэн үед сонины хэлний хэрхэн хувьссаныг үзүүлэх, гуравдугаарт: нийтэлсэн зүйлийг уншигчид хүлээж авч байна уу, үгүй юү гэдэг шалтгааныг олоход сонины редакцид туслах зэрэг зорилготой байдаг.

"Сонины хэл найруулгыг улам төгөлдөр болгоход анхаарах зүйлүүд байна. Юуны өмнө нийтэлж байгаа зүйл уншигчдад хялбар ойлгогдохоор энгийн тодорхой, тэдний сэтгэлийг хөдөлгөхөөр,

амьдрал ахуй, ажил үйлсэд тус болж чадахаар, сонирхолтой байх явдал юм".

ОНМХ-ээр олон нийтэд зориулагдаж байгаа аливаа мэдээлэл шуурхай, ойлгомжтой (тодорхой) байх чухал. Ойлгомжгүй байна гэдэг бол ямар нэг найруулгын алдаатай байна гэсэн үг. Мөн түүнчлэн элдэв гоё ганган чамин үг хэллэг, албархаг хатуу үг хэллэг хэрэглэх нь уг бичвэрийг ойлгоход төвөгтэй болгохын дээр үнэ цэнийг нь бууруулдаг. Гоё ганган болон албархаг юм анхнаасаа үнэ багатай байдаг. Үүнтэй холбон зарим судлаачид сонины хэл, найруулга аль болох ярианы хэлэнд ойр байх ёстой гэж үздэг. Тэгэхлээр нийтлэлийн хэл, найруулга бичгийн найруулгын нэг төрөл болохын хувьд ч гэсэн яавч ярианы найруулгатай нэг түвшинд байж таарахгүй. Нэг үгээр хэлбэл сонины хэл, найруулга энгийн үг хэллэгтэй, ойлгомжтой байх ёстой гээд, хэтэрхий болхи үг хэллэг, найруулгатай байж болохгүй гэсэн үг. ОНМХ-ийн нийтлэлийн хэлийг ярианы хэлэнд ойр байлгах нь нэг талаар зөвч, нөгөө талаар "ярьж байгаа мэт сонины нийтлэлийг бичих юм бол сонины хэл, найруулга гэж угаасаа байх хэрэггүй юм" гэсэн оновчтой санааг доктор Ч. Чойсамба онцлон тэмдэглэсэн байдаг.

Сонины хэл, найруулга дагавар, нөхцөл бүтээврээр үгийг зөв хэлбэржүүлсэн, үгийг оновчтой сонгосон, утга бүрхэгдүүлж хоёрдмол санаатай болгоо-

гүй, хэлний хэмнэлтийн зарчмыг ягштал баримтлан, үүрэггүй үг хэрэглэж, үг илүүдүүлээгүй, энгийн, ойлгомжтой үг хэллэгтэй байх нь зөв гэдгийг олон судлаач онцолсон байдаг. Тухайлбал: Английн Томсоны сангийн дээд дамжааны "Мэдээний машин" гарын авлагд: "Сэтгүүлчийн зорилго нь чухал зүйлийг олж нийтлэхээс гадна түүнийг ойлгоход дөхөмтэй болгох ёстой..." гэж тэмдэглэсэн бол. АНУ-ын "Ассошиэйтэд пресс" ("Associated press") агентлагийн лавлахад: "Жирийн уншигч уншаад ойлгож, тогтоож чадаж байвал, уг мэдээг уншихад дөхөмтэй болжээ гэж үздэг. Тодорхой ойлгомжтой байх нь энгийн хэлбэрээр бичигдсэн эсэхээс бүхэлдээ шалтгаална" гэсэн байна. Түүнчлэн Америкийн сэтгүүлч судлаач Лоуренс К. Боппе "Сайн сонин нийгмийн амьдралыг байгаагаар нь сайныг ч, саарыг ч адил тэгш тусгах ёстой. Тэгэхдээ энгийн, ойлгомжтой, аль болох товч байх нь илүү зохимжтой. Сэтгүүлчийн зорилго баримтыг чин сэтгэлээсээ өгүүлэхэд оршино. Мэдээллийн материалд зохиогчийн үзэл бодол байх ёсгүй" гэжээ. Тэгэхдээ аль XIII зууны үед монголчуудын ярианы болон бичгийн хэл ихээхэн ялгаатай байсан байхад, орчин үед ярьж байгаа мэт хэтэрхий болхи найруулгаар бичиж болохгүйг сэтгүүлч хүн ямагт анхаарч явах хэрэгтэй.

Сэтгүүлчийн гол зэвсэг нь хэлний боловсрол болж байгааг анхаарах

хэрэгтэй. Сонины зарим материалд хэт чамирхсан, нэг бол дэндүү болхи, чухам юу хэлэх гэсэн нь үл ойлгогдох байдал ажиглагдаж байна. Сонин хэвлэл ийм дутагдалаас аль болох зайлсхийж, гаргахгүй байх чухал. "Мэргэжлийн бус хүмүүс сэтгүүл зүйн байгууллагуудад олноор ажиллах болсон нь сонины редакциудад илүүтэй мэдрэгдэх болов. Нийт боловсон хүчний 30-50 хувийг, зарим редакцид 60-80 хувийг мэргэжлийн бус хүмүүс эзэлсэн нь, тэдгээрийн нийтлэл тодорхой хэмжээгээр ур чадварын хувьд сул, улмаар сонины гэхээсээ илүү энгийн ярианы найруулгын шинжийг агуулахад хүргэв. Сонины хэл энгийн ярианд ойртож, түүний шинжийг агуулах болсон нь эерэг, сөрөг үр дагаварын аль алийг дагуулсан юм. Сонины нийтлэл бүхэлдээ амьдралд ойр, сонирхолтой, энгийн, ойлгомжтой болов. Угаасаа сонины хэл ярианы хэлнээс эх ундаргаа аван, түүгээр "тэтгүүлдэг", түүнтэй эргэх харьцаатай байдаг болхоор энэ нь зүй ёсны үзэгдэл юм"².

Сонин хэвлэл бол нийт ард түмний хэлний боловсролд чухал нөлөө үзүүлдэг. Сонины хэл, найруулгын үгсийн бүрэлдэхүүн нь харьцангуй тогтвортой. Найруулга дундын шинжтэй буюу бараг бүх найруулгын үгээр бичигдэнэ гэсэн үг. Гэхдээ хэмжээтэй. Тухайлбал: Ирээдүйд адилтгал, зүйрлэл, ёгтлол, егөөдөл, ихэсгэл, багасгал зэрэг яруу хэрэглүүр; бүдүүлэг,

этгээд, харь, албархай, нутгийн аялгууны гэх мэт утга зохиолын хэлний идэвхгүй үгс, ажээ, санжээ, асан, болой, буй, авай, ажгуу, зэрэг хуучирч, үүргээ алдсан туслах үйл үгс; хийгээд, агаад, атал, ахул, аваас зэрэг хуучирсан холбох үгс нийтлэлийн найруулгад багасах байх.

Сонины хэл, найруулга дараах онцлог шинжүүдтэй:

- Сонины хэл, найруулга хэлний хэмнэл хийх боломжтой.

- Хэлний ялгаруулалт сайн хийнэ.

- Үгийн шууд, бодит утга давамгайлдаг.

- Шинэ үг хэллэгийн тухайн үндэсний хэлэнд оруулж ирдэг. Бусад дөрвөн найруулга, тэр дундаа албан бичгийн найруулга, уган зохиолын найруулга энэ талаар бүр ч боломж багатай. "Тухайн улс орны нийгэмд шинээр бий болж байгаа юм үзэгдэлийг тусган шинэ үг хэллэг үүсэхдээ сонины хуудсаар дамжин түгдэг"³

- Бичлэгийн төрөл, зүйлээс хамаарч дүрслэн илэрхийлэх арга зүйг тодорхой заагтай ашигладаг.

- Тухайн нэр томъёо хэвшиж тогтоогүй үед гадаад үг хэллэг хэрэглэнэ.

- Орчуулгын үг хэллэг, олон улсын нэр томъёо их хэрэглэдэг.

- Нэр үг, үйл үгийн тоо харьцангуй ойролцоо орно. Загварт найруулга, тэр дундаа эрдэм шинжилгээний найруулгад

нэр үгс (жинхэнэ нэр, тооны нэр), уран зохиолын найруулгад дүрслэх чадвар сайтай үйл үгс, тэмдэг нэр, голлодог бол, нийтлэлийн найруулга энгийн, ойлгомжтой, үгсийн бүрэлдэхүүн нь найруулга дундын шинжтэй, цөөн үгээр өргөн утга илэрхийлдгээрээ бусад дөрвөн найруулгаас давуу талтай.

- "Монгол хэлний үг бүтэх ёсны дагуу бэлэн байгаа үндэс дээр үг бүтээх дагавар залгаж шинэ үг хэллэг үүсгэх замаар үгийн санг баяжуулдаг".

- Хэлний хэмнэлтийн зарчимтай уялдуулан товчилсон үгийг сонин хэвлэлд хэрэглэж болно.

- Сонины үгийн сан өөрчлөгдөж хөгжихдөө хуучин хэрэглэж байсан үг хэллэгийг уламжлан хадгалж, илэрхийлэх хүрээг нь өргөтгөн баяжуулдаг.

- "Сонинд нийтэлж байгаа зүйлийн хэл, найруулгыг сайжруулах нь түүний утга агуулгыг яруу тод, сэтгэлд нийцтэй болгох, олон түмнийг хүмүүжүүлэх, танин мэдүүлэх боловсролыг дээшлүүлэх, утга зохиолын хэлийг улам боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой"⁴

- Өгүүлбэрийг нэг нэв маягаар төгөсгөх нь тухайн өгүүлж байгаа зүйлийн хэл найруулгыг сулруулдаг. Манай сонинуудад түгээмэл байгаа нэг дутагдал энэ юм.

- Сонины хэл, найруулга нийт уншигчийн хэлний боловсролд агшин тутамд нөлөөлдөг.

"Сонины хэл бол бичгийн хэлний бие даасан хэлбэр болохын хувьд шүлэг, өгүүлэг зэрэг уран зохиолын төрөл, зүйлээс эхлээд, улс төрийн үйл явдлын хатуу тогтсон хэвшмэл загвартай хэллэг байдаг. Эрдэмтдийн үзэж байгаагаар сонины хэл уран яруу дүрслэл, нэвшмэлжин тогтсон хэллэгийн харьцаа тэнцвэртэй байвал хэвийн хэл найруулгатай байна"⁵ гэж үзжээ.

"Сонин хэвлэлийн ажилтан хүн өөрөө бичихийн зэрэгцээгээр бусдын бичсэнийг найруулж засдаг

чадвартай байх хэрэгтэй. Хэл зүй зөв өгүүлэхийн хэм хэмжээг зөрчсөн, нэр томъёо буруу хэрэглэсэн, хоёрдмол утгатай, болхи найруулгатай зүйл сонин сэтгүүлд байх ёсгүй. Тогтоосон нэр томъёог нийтээр нэг мөр болгон хэрэглэхэд сонин хэвлэл гол үүрэг гүйцэтгэх ёстой"⁶.

"Сонины хэл утга зохиолын хэлний хэм хэмжээний дагуу байх ёстой. Энэ нь хэлний хөгжилийн тодорхой нэгэн үед нийгэм олноороо хамгийн зөв үлгэр жишээ болгон авч хэрэглэж байгаа хэлний бүтцийн онцлогтой, түүхэн уламжлалтай холбоотой байдаг. Хэлний хэм хэмжээг зөрчсөнөөс найруулгын

шаардлага хангаагүйгээс найруулгын алдаа үүсдэг"⁷.

"Сонины хэл хэвшмэлжсэн үг хэллэг, уран яруу үг хэллэгийн нэгдэл юм. Сонины хэл найруулга энгийн, уран байх ёстой. Уран яруу бичихийг эрхэмлэх нь

сонины хэлний нэг шаардлага"⁸ билээ.

"Сонины бичлэгийн төрлийн байдлаас хамааран, уран яруу болон хэвшмэлжсэн байдал хослох нь харилцан адилгүй байдаг. Зарим зүйлд уран яруу дүрслэл голлож байхад, заримд нь хэвшмэлж-

сэн байдал илүү байх жишээтэй"⁹.

Францын найруулга зүйч Р.Жеоржин "Найруулж сурахад эдэмшвэл зохих хамгийн чухал чанарууд бол: өгүүлж байгаа зүйл тодорхой, үг хэллэг оновчтой, үгийн баялаг арвин, нуршсан зүйлгүй товч, өөрийн гэсэн арга барилтай, уншигчдад цэгц ойлголт өгөх, гоёж гангалан чамирхсан зүйлгүй энгийн байх"¹⁰ гэжээ.

Үүн дээр найруулга зүйч Ц.Сүхбаатар: "ойлгомжтой, сонирхолтой, яруу сонсголонтой, гоо зүйн хэм хэмжээг харгалзсан байх"¹¹ гэсэн чанарыг нэмжээ.

"Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл, аливаа бичвэрт тавигдах найруулга зүйн үндсэн шаардлага бол:

«

*Нийтлэлийн редакторууд бол
сонин хамгийн найдвартай
хамгаалагчид байх учиртай. Тэд
түүнийг зөв бичих дүрэм зорчигдох,
мөн найруулга зүйн алдаа,
хариултгүй үлдсэн асуулт,
орхигдсон баримт, шүү үг,
тодорхойгүй байдал, үндэслэлгүй
дүгнэлт, буруу сонгосон үг хэллэг
зэргээс хамгаалдаг.*

»

1. Тодорхой (=ойлгомжтой)

2. Сонирхолтой

3. Аль болох хураангуй

4. Үг сонголт сайтай

5. Гоо зүйн болон учир зүйн хэм хэмжээнд тохирсон байх зэрэг болно.

Найруулга зүйн шаардлагыг хангахын тулд заавал өөрийн гэсэн арга барилтай байх хэрэггүй мэт санагдана. Хэдийгээр сэтгүүлч хүний хувьд энэ нь гарцаагүй чухал боловч, уг нийтлэл уншигчийн сонирхлыг татахуйц бичигдсэн бол арга барил төдийлөн чухал биш. Түүнчлэн уг хэллэг оновчтой байгаа нь үгийн баялаг арвин байгаагийн илрэл, мөн өгүүлж байгаа зүйл тодорхой бол уншигчдад цэгц ойлголт өгөх нь дамжиггүй"¹²

Ц. Сүхбаатар "Найруулгын тухай" номондоо найруулга сайтай нийтлэл бичихийн тулд эзэмшвэл зохих чанаруудад: хөдөлмөрч эрмэлзлэл, байнга ажиглах, уйгагүй унших, бүтээлч дууриал, бичих зүйлээ гүн ойлгох, зөв төлөвлөх, "амттай" бичих, үгийг оновчтой сонгох, яруу хэрэглүүрийг зохистой ашиглах, ахин дахин засах"¹³ зэргийг оруулсан нь мэдүүштэй.

Академич Д.Төмөртоогогийн хэлснээр: "...Сүүлийн жилүүдэд сонин, сэтгүүлийн хэллэг их муудсан. Гудамжны гэх төдийгүй, төрийн томоохон хэвлэлүүдэд ч тийм байдал ажиглагдаж байна. Сэтгүүл зүй гэдэг нь хэл, найруулгаас ангид байж болохгүй" юм.

"Бидний ажиглалтаар, найруулгын алдаанд хүрэгдэг үндсэн шалтгаануудыг доор сийрүүлбэл:

- Идэвхтэн бичигч, сэтгүүлч, сурвалжлагч (цаашид сэтгүүлч)-ийн мэргэжлийн мэдрэмж дутсан

- Сэтгүүлч найруулгын алдаануудыг мэдэхгүй байх

- Сэтгүүлчийн хувийн хариуцлагагүй байдал, ажилдаа тоомжиргүй хандах

- Сэтгүүлчийн залхуу хойрго байдал, бичсэн материалаа дахин уншиж хянаагүй

- Сэтгүүлчийн эх хэлний мэдлэг, боловсрол дутсан

- Сэтгүүлч бүтээлчээр эрэлхийлээгүй

- Сэтгүүлч бичсэн материалаа уншигчийн нүдээр хараагүй

- Сэтгүүлч бичих материалаа урьдчилан төлөвлөж, боловсруулаагүй

- Сэтгүүлч, бичлэгийн шилдэг хэлбэр бол яриа, хүүрнэл маягаар бичих явдал гэсэн үзлийг хэт туйлшруулсан

- Сэтгүүлч мэдээлэх, уншуулах гэж бус, харин бичсэн хэмээгдэх гэж бичсэн зэрэг болно.

Найруулгын алдаа гэж тухайн эх бичвэрийг уншигч хүлээн авч, ойлгоход ямар нэг хэмжээгээр хүндрэл учруулж, эргэлзээ, гайхал төрүүлж, унших явцыг алдагдуулж, уншигчийн анхаарлыг сарниулж, огт өөр юманд хандуулж буй дотоод зөрчил бүхий нэг, эсвэл хэд хэдэн үгийг хэлнэ"¹⁴

Доктор Ч.Чойсамба тогтмол хэвлэлийн материалд тулгуурлан найруулгын алдааг доорх байдлаар ангилжээ. Үүнд:

1. Тэмдэгтийн алдаа
2. Давтах алдаа
3. Хэл зүйн алдаа
4. Гоо зүйн алдаа
5. Учир зүйн алдаа
6. Утга ялгах үүрэгтэй үг орхих
7. Үг буруу сонгох
8. Үг буруу байрлуулах
9. Баримтын алдаа
10. Гарчиг, эх бичвэр зөрчилдөх

алдаа¹⁵ зэрэг багтаж байна.

Найруулга зүйч Ц.Сүхбаатар: "Сонин хэл найруулгыг хэл шинжлэлийн үүднээс гурав хуваадаг. Энэ ангилал нь яг хөдөлгөөнгүй загвар биш боловч сонины хэл найруулгыг хамгийн их судалсан Оросын хэл шинжлэлийн зарим зохиолууд үүнийг баримталж иржээ.

Нэгдүгээрт: уламжлан тогтсон хэлбэр.

Энэ нь хэл ярианы тогтсон өгүүлбэр зүйн бүтцийг ашигладаг. Уламжлан тогтсон энэ хэлбэрт тэргүүн өгүүлэл, илтгэл, хэвлэлийн тойм, албан мэдэгдэл, сонсгол, хэвлэлийн бага хурлын мэдэгдэл зэрэг дипломат болон албан ёсны мэдээний төрөл, зүйл багтдаг.

Хоёрдугаарт: тодорхой баримт болон мэдээллийг хослох хэлбэр. Энэ нь сэтгэл хөдлөлийн өнгө аяс, уран дүрслэл зураглал, хэлний яруу хэрэглүүр, шинэ амьсгал бүхий хэл ярианы бэлэн хэлбэрийг ашигладаг. Тодорхой баримт

болон мэдээллийг хослох энэ хэлбэрт сурвалжилсан тэмдэглэл, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, найруулал, сурвалжлага, талбарлагчийн өгүүлэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл зэрэг төрөл, зүйлийн хэл найруулгыг оруулжээ.

Гуравдугаарт: зохиогчийн өөрсдийн арга барилаар бичсэн хэлбэр. Зохиогч өөрийн арга барилаар хэлний янз бүрийн яруу хэрэглүүрийг өргөн ашиглаж, урнаар дүрслэн өнгө ялгарааг нарийн гаргадаг хэлбэр юм. Энэ хэлбэрт замын тэмдэглэл, шог найруулал, уншигчдын захидал, асуултанд хариулсан өгүүлэл, сурвалжилсан тэмдэглэл, зэргийг оруулж болно"¹⁶ гэж бичсэн байна.

Уран яруу болон хэвшмэлжсэн байдлыг хослохгүйгээр тухайн санааг энгийн, товч, тодорхой, яруу илтгэх аргагүй юм. Сонины аль нэг дугаарыг аваад үзэхэд, бичлэгийн янз бүрийн төрөл, зүйлийг хамардаг боловч цөм л уран яруу болон хэвшмэлжсэн байдал хосолж байдаг байна.

Сонины хэл, найруулга бол найруулгын үндсэн таван төрлийн дундаас хамгийн цэгцтэй, найруулга дундын шинжтэй, үг хэллэг нь энгийн, ойлгомжтой байдгаараа давуу талтай юм.

Нийтлэлийн редакторууд бол сонины хамгийн найдвартай хамгаалагчид байх учиртай. Тэд түүнийг зөв бичих дүрэм зөрчигдөх, мөн найруулга зүйн алдаа, хариултгүй үлдсэн асуулт,

орхигдсон баримт, илүү үг, тодорхойгүй байдал, үндэслэлгүй дүгнэлт, буруу сонгосон үг хэллэг зэргээс хамгаалдаг.

Сонинд редакторлагүй нэг ч материал нийтлэгдэх ёсгүй. Зарим томоохон сонинуудад материалыг нийтлэгдэхээс өмнө 2-3 хүн давхар редакторлан засах тохиолдол элбэг байдаг. Тухайлбал: Өнгөрсөн социалист нийгмийн үед "Үнэн" сонины материалыг 3-4 хүн гар дамжуулан уншиж хянан засварладаг байсныг дурьдаж болно.

Б арууны сэтгүүл зүйд гэхэд "сонины хэвлэгдэх хувь, бүтэц, зохион байгуулалтаас шалтгаалж материал жижүүр редактор, даалгавар өгсөн редактор, хэлтсийн эрхлэгч, мэдээлэл хариуцсан редактор, онцгой тохиолдолд хуваарилагч редактор болон ерөнхий редактор зэрэг хэд хэдэн хүний гар дамждаг.

Бичгээр илэрхийлж байгаа санаа бодол бүхэн утга зохиол болдог. Тэр утга зохиол бүрийг хянан тохиолдуулж ариутган шүүнэ.

Орчин үед бичгийн хэлний аль ч найруулгад, ялангуяа эрдэм шинжилгээний найруулга, сонины хэл найруулгад том том нийлмэл өгүүлбэр, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр, угсарсан нийлмэл өгүүлбэр, харилцан зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрүүд нэг их хэрэглэгдэхээ болиод байна. Энэ нь цөөн үгээр өргөн утга илэрхийлж байгаагаараа давуу талтай боловч нөгөө талаас утга бүхнийг

цөөхөн үгэнд багтааж байгаа нь бичгийн хэлийг ядуурахад хүргэж байгааг анхаарах хэрэгтэй боллоо. Иймээс эх бичвэрийн доторх өгүүлбэрүүдийг өгүүлбэрийн гол гишүүдээс бүтсэн энгийн өгүүлбэрээр бичихээс гадна нийлмэл өгүүлбэрүүдийг ч цэгцтэй сайхан найруулан бичиж баймаар байна.

Ишлэл

¹ Сүхбаатар Ц., Отгонсүрэн Д., Баярсүрэн Ц. 1991. Монгол хэлний найруулгын төрөл. УБ. 41 дэх тал.

² Сүхбаатар Ц. 1982. Сонины хэл, найруулга // "Сэтгүүлч". №3.

³ Чойсамба Ч. 2004. Сонины хэл, найруулга. УБ. 98-99 дэх тал.

⁴ Сүхбаатар Ц. 1984. Сонины хэл, найруулга // "Сэтгүүлч". №2.

⁵ Сүхбаатар Ц. 1973. Сонины хэл, найруулга // "Шинжлэх ухаан, амьдрал". №2.

⁶ Отгонсүрэн Д., Сүхбаатар Ц., Баярсүрэн Ц. Дурд. зох. 44 дэх тал.

⁷ Норовсүрэн Л. 1996. Редакторлах зүйн онол дадлага. УБ. 96 дахь тал.

⁸ Хасбаатар Ц. 1986. Хянан найруулах эрдэм. УБ. 37 дахь тал.

⁹ Сүхбаатар Ц. 1984. Сонины хэл, найруулга // "Сэтгүүлч". №4.

¹⁰ Сүхбаатар Ц. 1998. Монгол хэлний найруулга зүй. УБ. 278-279 дэх тал.

¹¹ Ишлэлийг: Сүхбаатар Ц. 1985. Орчин цагийн монгол хэлний найруулга зүй. УБ. 10-11 дэх тал.

- ¹² Ишлэлийг: Чойсамба Ч. Дурд. зох. 15 дахь тал.
- ¹³ Ишлэлийг: мөн зох. 16 дахь тал.
- ¹⁴ Чойсамба Ч. Дурд. зох. 17 дахь тал.
- ¹⁵ Мөн зох. 18 дахь тал.
- ¹⁶ Сүхбаатар Ц. 1973. Сонины хэл, найруулга // "Шинжлэх ухаан, амьдрал". №2.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
2. Норовсүрэн Л. 1996. Редакторлах зүйн онол дадлага. УБ.
3. Отгонсүрэн Д. 1996. Монгол хэлний хэл зүйн найруулгын өгүүллүүд. УБ.
4. Отгонсүрэн Д. 1998. Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй. УБ.

5. Отгонсүрэн Д. 1995. Эх зохиох товч гарын авлага. УБ.
6. Сүхбаатар Ц., Отгонсүрэн Д., Баярсүрэн Ц. 1991. Монгол хэлний найруулгын төрөл. УБ.
7. Сүхбаатар Ц. 1993. Найруулан бичих арга ухаан. УБ.
8. Сүхбаатар Ц. 1998. Монгол хэлний найруулга зүй. УБ.
9. Хасбаатар Ц. 1986. Хянан найруулах эрдэм. УБ.
10. Чойсамба Ч. 2004. Сонины хэл найруулга. УБ.
11. Brooks I. 1988. News Reporting and writing. New York.
12. Kennedy G. 1988. News Reporting and writing. New York.
13. Moen F. 1988. News Reporting and writing. New York.